

## **“Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг, нийгмийн байдлыг судалсан шинжилгээ, үр дүн**

### **Үндэслэл:**

Монгол нутагт шинэ чулуун зэвсгийн үед малыг гэршүүлж улмаар хүрлийн үе буюу өдгөөгөөс 5000 орчим жилийн тэртээгээс амьдрал, ахуйн гол зүйл болгон хэрэглэсээр ирсэн бөгөөд одоо ч манай улсын эдийн засгийн голлох салбарын нэг юм. Өмнөговь аймгийн хэмжээнд 2017 оны жилийн эцсийн мал тооллогоор нийт 7418 малтай өрх үүнээс 5819 малчин өрх, 9635 малчинтай гэх үзүүлэлт гарсан байна. Энэ нь Өмнөговь аймгийн нийт өрхийн 34.9 хувь нь малтай өрх, 27.3 хувь нь малчин өрх, нийт хүн амын 14.7 хувь нь мал аж ахуй эрхэлдэг гэсэн судалгаа гарч байна.

Малчдын ахуй амьдралын нөхцөл нь техник, технологийн хөгжил, нийгэм, эдийн засгийн байдлаас хамааран сайжирч байгаа хэдий ч төв суурин газрын иргэдтэй харьцуулахад ихээхэн ялгаатай байна. Иймд малчдын эрүүл мэндийг ахуй, амьдралын нөхцөлтэй нь холбон судалж, тэдгээрийн ахуй, амьдралын нөхцөл, эрүүл мэндийг сайжруулахад чиглэсэн нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Зорилго:**

Малчдын ахуй амьдрал, эдийн засаг, эрүүл ахуйн нөхцөл, байдлыг судлах.

### **Хамрах хүрээ:**

Өмнөговь аймгийн 15 сумын 58 баг. Баг бүрээс санамсаргүй түүврийн аргаар 4 малчин өрх сонгоно. Ханбогд сумын Хайрхан багийн 2, Цогтцэций сумын Өгөөмөр багийн 2, Даланзадгад сумын Далангийн 3-р багийн 3 өрх малчин сонгогдсон. Нийт 215 малчин өрх.

**Зохион байгуулагдах хугацаа:** 2018.06.15-06.28

### **Үр дүн:**

Мал аж ахуй эрхлэгч өрхийн орлогын зөрүү түүний шалтгаан, ахуй амьдрал, аж ахуйдаа зарцуулдаг цагийн хуваарь, Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал төлдөг эсэх, МAA-тай холбоотойгоор гарсан эрүүл мэндийн байдал, өвчлөл, түүнээс урьдчилан сэргийлэх мадлэгтэй эсэх, мөн эрүүл мэнд болон нийгмийн байдлын хувьд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар санал бодлын илэрхийлэх.


Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг, нийгмийн байдлын судалгааны маягт:

**Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг,  
нийгмийн байдлын судалгаа**

**Зорилго:** Малчдын ахуй амьдрал, эдийн засаг, эрүүл ахуйн нөхцөл, байдлыг судлах

1. Малчны овог нэр: .....
2. Таны нас: .....
3. Таны хүйс: А. Эр В. Эм
4. Харьяа сум, баг: .....
5. Сууцны төрөл: А. Гэр : а. 3 б.4 с.5 d.6  
В. Байшин  
С. Сууцны зориулалтаар хийгдсэн чирэгч пин.  
D. Бусад /бичих/.....
6. МAA эрхлэхдээ ашигладаг унаа, техник: А. Морь, Тэмээ  
В. Мотоцикль  
С. машин  
D. Бусад /бичих/.....
7. Малын тоо: .....
8. МAA-н жилийн орлого /мян.төгрөгөөр/:  
А. 100.0-499.0 В. 500.0-1000.0 С. 1000.0-5000.0 D. 5000.0 дээш
9. Өдөрт МAA-даа зарцуулдаг цаг: /бичих/ .....
10. Нийгмийн даатгал төлдөг эсэх: А. Тийм В. Үгүй
11. Эрүүл мэндийн даатгал төлдөг эсэх: А. Тийм В. Үгүй
12. Танай өрхийн бие засах байгууламж:  
А. Ил задгай В. Нүхэн жорлон С. Стандартын жорлон D. Бусад/бичих/.....
13. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг эсэх:  
А. Тийм В. Үгүй
14. Сүүлийн нэг жилийн хугацаанд хэдэн удаа эмнэлэгийн байгууллагаар үйлчлүүлсэн бэ?  
А. Үйлчлүүлээгүй В. 1-5 удаа С. 5-10 удаа D. 10 дээш удаа
15. Мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор эрүүл мэндийн хувьд эмнэлэгт хандаж байсан эсэх: А. Тийм В. Үгүй
16. Малын халдварт өвчний талаар хэр сайн мэдлэгтэй вэ?  
А. Мэдэхгүй В. Бага зэрэг мэдлэгтэй С. Мэднэ D. Сайн мэднэ
17. Халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэг чадвартай эсэх:  
А. Тийм В. Үгүй
18. Малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулах асуудал дээр таны байр суурь:  
А. Дэмжиж байна. В. Дэмжихгүй байна.
19. Эрүүл мэнд болон нийгмийн байдлын хувьд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар санал бодлоо хуваалцана уу.  
.....  
.....  
.....

Судалгаанд хамрагдсан таньд Аз жаргал хүсье.

Баярлалаа. 

Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг, нийгмийн байдлын судалгаанд хамрагдсан нийт 215 малчны мэдээлэл дээр тулгуурлан SPSS программыг ашиглан дараах шинжилгээнүүдийг хийсэн болно.

**Судалгаанд хамрагдсан малчдын хүйсийн харьцаа:**



Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг, нийгмийн байдлын судалгаанд 20-85 насны 172 (80.0 %) эрэгтэй, 43 (20.0%) эмэгтэй, нийт 215 малчин хамрагдсан. Мал аж ахуй эрхлэгчдийн дундаж нас 44 байна.

**Мал аж ахуй эрхлэгчдийн сууцны төрөл:**

Сууцны төрөл		Малчин өрхийн тоо	Нийт өрхөд эзэлж буй хувь
1	Гэр	182	84.7
2	Гэр байшин	8	3.7
3	Гэр байшин сууцны зориулалтаар хийсэн чирэгч пин	1	0.5
4	Гэр сууцны зориулалтаар хийсэн чирэгч пин	5	2.3
5	Гэр бусад	1	0.5
6	Байшин	13	6.0
7	Байшин сууцны зориулалтаар хийгдсэн чирэгч пин	3	1.4
8	Сууцны зориулалтаар хийсэн чирэгч пин	1	0.5
9	Бусад	1	0.5
Нийт		215	100.0

Судалгаанд хамрагдсан нийт малчин өрхийн 84.7 хувь нь буюу 182 өрх нь гэрт, 3.7 хувь буюу 8 өрх гэр байшин хослуулан, 0.5 хувь нь буюу 1 өрх гэр байшин сууцны зориулалтаар хийсэн чирэгч пинг хослуулан, 2.3 хувь нь буюу 5 өрх гэр сууцны зориулалтаар хийсэн чирэгч пинг хослуулан, 0.5 хувь нь буюу 1 өрх гэр бусад сууцыг хослуулан, 6.0 хувь нь буюу 13 өрх байшинд, 1.4 хувь буюу 3 өрх байшин, сууцны зориулалтаар хийсэн чирэгч пинг хослуулан, 1 өрх сууцны зориулалтаар хийсэн пинд, 1 өрх бусад сууцанд амьдран нүүдлийн аж ахуйг эрхэлж байна.

Мал хариулахдаа ашиглаж буй унааны төрөл нь малчдын малын тоо болон, мал аж ахуйгаар олдог орлого зэргээс хамааран ялгаатай байна.

### Мал аж ахуй эрхлэхдээ ашигладаг унаа техник:


Техник хэрэгслийн төрөл		Малчин өрхийн тоо	Нийт өрхөд эзэлж буй хувь
1	Морь тэмээ	6	2.8
2	Морь тэмээ мотоцикль	26	12.1
3	Морь тэмээ мотоцикль машин	20	9.3
4	Морь тэмээ машин	1	.5
5	Мотоцикль	109	50.7
6	Мотоцикль Машин	35	16.3
7	Машин	10	4.7
8	Бусад	8	3.7
Нийт		215	100.0

Дүгнэлт: 1 Судалгаанд хамрагдсан мал аж ахуй эрхлэгчдийн 190 буюу 88.4\* хувь нь мотоциклиор, 66 буюу 30.8\* хувь нь машинаар, 53 буюу 24.7\* хувь нь морь тэмээгээр, 3.7 хувь нь бусад тээврийн хэрэгслээр малаа хариулж байна. Малчид мотоциклийг мал аж ахуй эрхлэхдээ түлхүү хэрэглэж байна.

**\*хариулагч 1 ба түүнээс дээш хариулт сонгосон тул хувийг давхардсан тоогоор хувилсан болно.**

Дүгнэлт: 2 Судалгаанд хамрагдсан мал аж ахуй эрхлэгчдийн 6 буюу 2.8 хувь нь морь тэмээгээр, 26 буюу 12.1 хувь нь морь тэмээ мотоциклийг хослуулан, 20 буюу 9.3 хувь нь морь тэмээ мотоцикль машиныг хослуулан, 1 буюу 0.5 хувь нь морь тэмээ машин хослуулан, 109 буюу 50.7 хувь нь мотоциклиор, 35 буюу 16.3 хувь нь мотоцикль машин хослуулан, 10 буюу 4.7 хувь нь машинаар, 8 буюу 3.7 хувь нь бусад тээврийн хэрэгсэлээр малаа хариулж байна.

### МАА ЭРХЛЭХДЭЭ АШИГЛАДАГ УНАА ТЕХНИК




Судалгаанаас харахад манай аймгийн хувьд мотоциклиор ихэвчлэн малаа хариулж байна.

Судалгаанд хамрагдсан:

- 0-300 малтай 85 малчин байгаагийн 64 нь буюу 75.3 хувь нь мотоциклоор, 11 нь буюу 24.7 хувь нь морь тэмээ, бусад тээврийн хэрэгслээр,
- 301-600 малтай 48 малчин байгаагийн 43 буюу 89.9 хувь нь мотоциклоор
- 601-900 малтай 26 малчин байгаагийн 26 буюу 100.0 хувь мотоцикль ашигладаг ба 8 өрх нь морь тэмээ, машин, мотоцикль хослуулан ашигладаг.
- 901-ээс дээш малтай 48 малчин байгаагийн 48 нь буюу 100.0 хувь мотоцикль ашигладаг ба 29 өрх нь морь тэмээ, машин, мотоцикль хослуулан ашигладаг байна.

Дээрх хүснэгт графикыг малын тоо болон мал аж ахуйгаас олдог орлоготой харьцуулан үзэхэд мал аж ахуйгаас олдог орлого нэмэгдэхийн хирээр мал аж ахуй эрхлэхдээ ашигладаг техник хэрэгсэл нэмэгдэж, ажил ачааллыг илүү их хөнгөвчилж байна.

#### **Мал аж ахуйн жилийн орлого:**



Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан малчин өрхийн МАА-н жилийн орлого 100.0-499.0 мянган төгрөгний орлоготой 10 өрх буюу 4.7 хувь, 500.0-1000.0 мянган төгрөгний орлоготой 26 өрх буюу 12.1 хувь, 1000.0-5000.0 мянган төгрөгний орлоготой 69 өрх буюу 32.1 хувь, 5000.0 мянган төгрөгнөөс дээш орлоготой 110 өрх буюу нийт өрхийн 51.2 хувь нь байна.

Мал аж ахуйгаас олдог орлого нь малын тооноос шууд хамааралтай байна. Энэ нь малчин өрхийн малын тоо өсөхөд мал аж ахуйгаас олдог орлого дагаж нэмэгдэнэ, харин малын тоо буурахад орлого дагаж буурч байна.

**Мал аж ахуйдаа зарцуулдаг цаг:**

Зарцуулдаг цаг	Өрхийн тоо	Нийт малчинд эзлэх хувь	Өрхүүдийн малын тооны дундаж
4.0	1	0.5	68
6.0	4	1.9	437
6.5	2	0.9	178
7.0	2	0.9	593
8.0	11	5.1	394
8.5	2	0.9	873
9.0	11	5.1	470
9.5	1	0.5	634
10.0	26	12.1	470
11.0	17	7.9	425
12.0	54	25.1	496
13.0	23	10.7	563
13.5	3	1.4	643
14.0	12	5.6	703
15.0	6	2.8	681
16.0	7	3.3	807
16.5	4	1.9	514
17.0	4	1.9	340
18.0	1	0.5	232
Хариулт өгсөн нийт малчин	191	88.8	513
Хариулаагүй	24	11.2	
Нийт	215	100.0	

Мал аж ахуй эрхлэхэд зарцуулдаг цаг гэсэн асуумжинд 191 малчин хариулт өгч, 24 малчин хариулаагүй байна. Хариулт өгсөн малчдын 34 буюу 17.8 хувь нь 4.0-9.5 цаг зарцуулдаг. 157 малчин буюу 82.2 хувь нь 10.0-18.0 цаг зарцуулж байна. Мал аж ахуйд зарцуулсан цагийг малын тоотой харьцуулахад хоорондоо хамааралгүй байна.


### Нийгмийн болон эрүүл мэндийн даатгал төлдөг эсэх:

Нийгмийн даатгал төлдөг эсэх		
	Малчны тоо	Хувь
Хариулаагүй	4	1.9
Тийм	107	49.8
Үгүй	104	48.4
Нийт	215	100.0

Эрүүл мэндийн даатгал төлдөг эсэх		
	Малчны тоо	Хувь
Хариулаагүй	1	0.5
Тийм	175	81.4
Үгүй	39	18.1
Нийт	215	100.0


#### НДаатгал Төлөлт

■ тийм ■ үгүй ■ хариулаагүй



#### ЭМДаатгал төлөлт

■ тийм ■ үгүй ■ хариулаагүй



Дүгнэлт: 215 малчны 107 малчин буюу 49.8 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөг бол 104 малчин буюу 48.4 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлдөггүй байна. 4 малчин буюу 1.9 хувь нь хариулт өгхөөс татгалзсан байна.

2015 малчны 175 малчин буюу 81.4 хувь нь эрүүл мэндийн даатгал төлдөг бол 39 малчин буюу 18.1 хувь нь эрүүл мэндийн даатгал төлдөггүй байна. Харин 1 малчин буюу 0.5 хувь нь хариулт өгхөөс татгалзсан байна.

**Малчин өрхийн бие засах байгууламж:**

Бие засах байгууламжийн төрөл	Малчин өрхийн тоо	Нийт мал өрхөд эзлэх хувь
Ил задгай	71	33.0
Нүхэн жорлон	128	59.5
Стандартын жорлон	5	2.3
Бусад	11	5.1
Нийт	215	100.0

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан 215 малчины 71 нь буюу 33.0 хувь нь ил задгай бие засдаг бол, 128 нь буюу 59.5 хувь нь нүхэн жорлонд, 5 буюу 2.3 хувь нь стандартын жорлонд, 11 буюу 5.1 хувь нь бусад бие засах байгууламж ашиглаж байна. Нүхэн жорлон болон стандартын жорлон ашигласнаар эрүүл мэнддээ гарч болзошгүй халдварт өвчнөөс сэргийлж чадах юм. Малчдын 61.8 хувь буюу 133 малчин дээрх 2 төрлийн бие засах байгууламжийг ашиглаж байна.

**Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах мэдлэг чадвар, мал аж ахуй эрхлэхтэй холбоотой гарсан өвчлөлийн талаар:**

	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан эсэх	Мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор эрүүл мэндийн хувьд эмнэлэгт хандаж байсан эсэх	Халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэг чадвартай эсэх
Хариулаагүй	2	3	4
Тийм	162	66	136
Үгүй	51	146	75

Дүгнэлт: судалгаанд хамрагдсан малчдын 162 нь буюу 75.3 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг бол 51 буюу 23.7 хувь нь ямар нэгэн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаггүй байна. 2 малчин буюу 0.9 хувь нь энэхүү асуумжинд хариулахаас татгалзсан байна.

Мал аж ахуй эрхэлж буй малчингаас эрхэлдэг ажилтай холбоотойгоор эрүүл мэндийн хувьд эмнэлэгт хандаж байсан эсэх талаар тодруулахад 66 малчин буюу



30.7 хувь нь тийм гэсэн хариулт өгсөн бол 146 малчин буюу 67.9 хувь нь эмнэлэгт хандаж байгаагүй гэсэн хариулт өгсөн байна. 3 малчин энэ асуултанд хариулахаас татгалзсан байна.

Малын халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэгтэй эсэх дээр нийт малчны 136 буюу 63.3 хувь нь бүрэн мэдлэгтэй гэсэн бол, 75 буюу 34.9 хувь нь мэдлэг дутмаг өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэг ойлголт байхгүй гэж хариулсан байна. 4 малчин хариулт өгөхөөс татгалзсан байна.

Дээрх үзүүлэлтүүдээс харахад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан 162 малчны 54 буюу 33,3 хувь нь мал аж ахуйтай холбоотойгоор эрүүл мэндийн хувьд эмнэлэгт хандаж байсан, 105 буюу 64.8 хувь нь эмнэлэгт хандаж байгаагүй гэж хариулсан байна. Мөн үзлэгт хамрагдсан малчдын 112 буюу 69.1 хувь нь халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэгтэй бол 48 буюу 29.6 хувь нь малын халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах мэдлэг хомс байна.

Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй 51 малчны 12 буюу 23.5 хувь нь мал аж ахуйтай холбоотойгоор эрүүл мэндийн хувьд эмнэлэгт хандаж байсан, 39 буюу 76.5 хувь нь эмнэлэгт хандаж байгаагүй гэсэн байна. Мөн үзлэгт хамрагдаагүй малчдын 23 буюу 45.1 хувь нь малын халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах мэдлэгтэй бол, 26 буюу 54.9 хувь нь өөрийгөө хамгаалах мэдлэг дутмаг гэж хариулжээ.

Харин халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах мэдлэгтэй 136 малчны 82.3 хувь нь урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан бол, 23 буюу 16.9 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй байна. Мөн 136 малчны 72.1 хувь буюу 98 малчин мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор эмнэлэгт хандаж байсан гэсэн бол 26.5 хувь буюу 36 малчин эмнэлэгт хандаж байгаагүй гэж хариулжээ.

Үүнээс нэгтгэн дүгнэлт гаргавал мал аж ахуй эрхлэхтэй холбоотойгоор гарах халдварт өвчнөөс өөрийгөө хамгаалах бүрэн мэдлэг чадвартай хүмүүс эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт илүү хамрагддаг ба эмнэлэгт хандах нь бага байна.

Малчдаас авсан судалгаанд эрүүл мэнд болон нийгмийн байдлын хувьд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар санал бодлын хуваалцахад санал бодлоо хуваалцсан 85 малчны дийлэнх нь жилдээ дор хаяж нэг удаа нарийн мэргэжлийн эмнэлэгт, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж байх, жилийн 4 улиралд малаа дагаж нүүдлийн аж ахуй эрхэлдэг төв суурин газар орж ирэх нь хомс байдаг тул хөдөө баг сумдаар явж үзлэг оношилгоо хийдэг байх талаар дурьдсан байсан.

Судалгааны ажлын үр дүн дүгнэлтийг үндэслэн зөвлөмж гаргахад малчдын эрүүл мэндийн болон малын гоц халдварт өвчний талаар өргөн дэлгэр мэдээллийг өрх, баг, сумын түвшинд малчдад олгосноор малчдын өөрсдийн эрүүл мэнддээ анхаарах хандлага нэмэгдэж, мал аж ахуй эрхлэхтэй холбоотой гарах өвчлөл багасах болно.

**Сүүлийн нэг жилийн хугацаанд хэдэн удаа эмнэлэгийн байгууллагаар үйлчлүүлсэн бэ?**

Үйлчлүүлсэн тоо	Малчдын тоо	Нийт малчинд эзлэх хувь
Хариулаагүй	2	0.9
Үйлчлүүлээгүй	61	28.4
1-5 удаа	146	67.9
5-10 удаа	3	1.4
10 дээш удаа	3	1.4
Нийт	215	100.0

215 малчдын маань 67.9 хувь буюу 146 малчин жилдээ 1-5 удаа эмнэлэгийн байгууллагад ханддаг бол, 61 буюу 28.4 хувь нь эмнэлэгийн байгууллагад хандаагүй гэсэн байна.

**Малын халдварт өвчний талаар хэр сайн мэдлэгтэй вэ?**

		Малчдын тоо
Сонголтууд	Хариулаагүй	2
	Мэдэхгүй	13
	Бага зэрэг мэдлэгтэй	116
	Мэднэ	60
	Сайн мэднэ	24
Нийт		215

**Малын халдварт өвчний талаар мэдлэгтэй эсэх**



Малчдын 11.0 хувь нь малын халдварт өвчний талаар сайн мэднэ гэсэн бол, 28.0 хувь нь тодорхой хэмжээний мэдлэгтэй, 54.0 хувь нь буюу дийлэнх нь бага зэрэг мэдлэгтэй, 6.0 хувь нь огт мэдэхгүй, 1.0 хувь нь хариулт өгөхөөс татгалзсан байна.



Боловсруулсан асуулгын хуудсан дээр малчдын тэтгэврийн насыг 5 жилээр наашлуулж байгаа тал дээр байр суурийн сонсоход судалгаанд сонгогдсон 215 малчин 100.0 хувь дэмжсэн байна.



***Эрүүл мэнд болон нийгмийн байдлын хувьд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар санал бодлоо хуваалцана уу? гэсэн асуумжинд малчин дараах санал санаачлага, өөрийн үзэл бодлоо хуваалцлаа:***

Доорх санал хүсэлтийг нэгтгэвэл:

- ✚ Эрүүл мэндийн талаар буюу Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдах, сум багийн түвшинд нарийн мэргэжлийн эмчийн орон тоог нэмэгдүүлэх, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын шимтгэл дээр хөнгөлөлт болон буцаалт олгож байх, эрүүл мэндийн талаар сургалт сурталчилгааг малчдад зохион байгуулах, эмнэлэгийн байгууллагаар үйлчлүүлэхэд хөнгөлөлт үзүүлж, оочир дараалалгүй үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг өрхөд газар дээр нь очиж хүргэдэг болох гэсэн саналыг нийт санал өгсөн 85 малчны 53 нь гаргасан байна.
- ✚ Малын бэлчээр болон бэлчээрийн даац, бэлчээрийн хомсдол ихээр бий болж байгаатай холбогдуулан эрчимжсэн мал аж ахуйг бий болгох малын тоог багасгах, чанартай сайн үүлдрийн мал сүргийг өсгөж үржүүлэх талаар 7 малчин санал гаргасан
- ✚ Өмнөговь аймаг нь говийн бүсд харьяалагддаг, газар нутгийн хувьд хуурайшилттай худаг усны гарц муу байгаатай холбоотой хүн малын амны ус болох гүний худгийг олон тоогоор гаргах саналыг 6 малчин
- ✚ Малчдын нийгмийн даатгал төлөлтийн хугацааг багасгах, хамтарсан тэтгэвэрийн бодлогыг бий болгох, тэтгэвэрийг үр хүүхдэд нь өвлүүлдэг байх гэсэн саналыг 5 малчин
- ✚ Нийгмийн даатгалын шимтгэлийг багасгах, тодорхоой хувийг төр хариуцдаг болох гэсэн саналыг 4 малчин
- ✚ Малын махны экспортыг дэмжих, малын махыг борлуулахдаа махны ченжээр дамжуулахгүй малчин хэрэглэгч 2 шууд борлуулалт

- нийлүүлэлт хийх гэсэн саналыг 2 малчин
- + Малын угаалга, тарилгыг жил бүр хийх, мөн малын эмчийг мэргэшүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бий болгох гэсэн саналыг 2 малчин
- + Залуу малчдаа малжуулах төсөлд түлхүү хамруулах, төрөөс дэмжих гэсэн саналыг 1 малчин
- + Арьс ширний үйлдвэрийг орон нутагтаа бий болгох гэсэн саналыг 1 малчин
- + Орон нутагт өгч байгаа газрын лицензийн асуудлыг багасгах, маш олноор нээгдэж буй уул уурхайн компани болон тээвэрлэлт, хөрсний эвдрэл гэмтэл, бохирдол, хүний амь, малын хорогдлын талаарх саналаа 1 малчин
- + Хувийн эзэмшлийн зунжаа, хаваржаа, худаг усан сан, малын бэлчээрийн маргааныг шийдвэрлэж өгөх талаар 1 малчин санал хүргүүлсэн байна.

**Малчдын санал хүсэлтүүд:**

1. Багийн эмчийн унааны бензин нэмэх, сард 40,0-50,0 болгох, айлууд багаас 80-100 км хол бензин хаана ч хүрдэггүй цалингаараа бензин хийдэг
2. Бууц хороо ариутгуулж малыг үзлэг тарилгад хамруулмаар байна
3. Гүний худаг гаргах, өөрийн хороо бууцтай болох, малын угаалга хийлгэх, малын тарианы хангамж, үнэ ихтэй монголын үйлдвэрийн эм тариагаар хангах
4. Дамын махны ченж нарын үйл ажиллагааг зохицуулах хэрэгтэй. малчин хэрэглэгч 2 шууд худалдаа хийх боломж гарц хайх цаг болсон
5. Жилд 1 удаа бүх мэргэжлийн эмч нар баг дээр ирж үзлэг хийж байх / урьдчилан сэргийлэх/
6. Жилд 1 удаа эмчийн нэгдсэн үзлэгч оруулж байх
7. Жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамрагдаж баймаар байна.
8. Залуу малчдыг төрөөс дэмжиж аж ахуй эрхлэх сургалт хийх
9. Зуны эхэн, намрын 10 сард малчдын эрүүл мэндийн үзлэгт оруулах, ном сонингоор хангах, бэлчээр усны хомсдолтой худаг ихээр гаргах, оюутан сурагчдыг тэтгэлэгт хамруул
10. МАА-н тоо өсөөд чанаргүй мал бий болж байна, Эрчимжсэн МАА хэрэгтэй байна. малын эмч мэргэжлийн бус хүн байх юм. мал өвдлөө гэхлээр эм тариа малчдад өгч явуулж байна.
11. Малжуулах төсөлд хамрагдах хүсэлтэй байна.
12. Малчдад нэгдсэн журмаар бүсчилж эсвэл сумаар нь үзлэгт 2 жилд 1 удаа хамруулж байх
13. малчдыг 2 жилд 1 удаа нарийн мэргэжлийн эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх

14. Малчдыг жилд 1 удаа зохион байгуулалттайгаар эрүүл мэндийн үзлэгт хамруулж байх
15. Малчдыг жилд 1 удаа үнэгүй буюу хөнгөлөлттэй эмнэлэгийн урьдчилсан шинжилгээнд хамруулж байвал зүгээр байна.
16. Малчдыг улиралд 1 удаа явуулын үзлэг шинжилгээнд хамруулах
17. Малчдыг хөнгөлөлттэй йнөхцөлөөр хамруулах
18. Малчдыг эмчийн үзлэгт үнэ төлбөргүй хамруулж байх, төсөлд хамрагдсан малчин өрхийг банкны зээлд хамруулдаг болгох
19. малчдыг эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэлийг төр 50 хувийг даах
20. Малчдыг эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа нэгдсэн журмаар хамруулах, малчин өрхийн 2 оюутантай өрхөд дэмжлэг үзүүлж байхыг санал болгож байна
21. Малчдыг эрүүл мэндийн үзлэгч хамруулах
22. Малчдын өвддөг тоотой хэдхэн өвчин байна. ходоод элэг зүрх үе мөч. эдгээр өвчнийг эмчлэх амьдралын зөв хэвшлийг суулгах хэрэгтэй
23. малчдын тэтгэвэрийг адил тэгш нэмэх
24. малчдын эрүүл мэнд болон нийгмийн даатгалын төлөлт өндөр байна. нэг айлын 2 малчин төлөх хүндрэлтэй байна.
25. малчдын эрүүл мэнд нийгмийн даатгалыг төрөөс анхаарах
26. Малчдын эрүүл мэндийг нэмэгдүүлэх, төсөл арга хэмжээ зорилтот бүлгээ онохгүй байна.
27. Малчдын эрүүл мэндийн тал дээр анхаарч байх
28. Малчдын эрүүл мэндийн үзлэг баг бүрт хийх
29. малчид өвчнөө эрт оношлуулах урьдчилан сэргийлэх боломжоор хангах хэрэгтэй
30. малчидаар орж үзлэг оношилгоо хийх
31. Малчидаар явж үзлэг оношилгоо хийж байх
32. Малчин бидний эрүүл мэндэд анхаарах
33. малын тоо мөн бэлчээр худаг ус харамлах асуудлыг зохицуулсан хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх
34. Малын тоог хязгаарлах хэрэгтэй, мал хэт өссөнөөр бэлчээр олдохгүй ган зуд байнга болох хор уршиг үүсээд байна
35. Малын угаалгыг жилд 1 удаа хийж баймаар байна.
36. малын халдварт өвчний талаар сургалт суртагчилгааг хийж байх
37. махыг эксдортонд гаргах, арьс шир нь үйлдвэрийн бодлогоор дэмжих
38. Маш олон лецинз уул уурхайн олборлох эрх өгч байгаа нь өнөөдрийн гамшиг болоод байна
39. МОН-СО эмнэлэгийг авчирч үзлэг хийлгэх онош тодорхойлох
40. мэргэжлийн эмч сувилагчийн үйлчилгээг хөдөө багт тогтмол хүргэх, нийгмийн даатгалын төлөлт гэрээг уян хатан

41. нийгмийн даатгалын шимтгэл төлөхөд маш хүндрэлтэй, боломж муу байдаг, өгсөнөөр ашиг байхгүй
42. нийгмийн даатгалын шимтгэлийг багасгах
43. нийт багийн эмч нар багийнхаа айл өрхүүдийг сар бүр хэсч эрүүл мэндийн үзлэгч сайн хамруулж байх
44. нөхөн тооцох талаар санал гаргах хэрэгтэй байна.
45. Сум орон нутагт нарийн мэргэжлийн эмч нарыг ирүүлж баймаар байна
46. сумдыг нарийн мэргэжлийн эмч нараан хангах, мал эмнэлэгийг улсын мэдлийх болгох
47. Сургалт семинар үзлэг оношилгоонд хамруулах
48. сургуулийн хүүхдийг эмнэлгийн үзлэгт сайн хамруулж баймаар байна
49. Төрөөс үйлчилгээ үзүүлэхдээ жаахан тааруу байдаг
50. тэтгэвэрийг 20 жил биш 12 жилээр төлөх, худаг усан хангамж муу
51. улиралд 1 удаа болдог багийн хурлаар малчдад эрүүл мэнд болон нийгмийн даатгалын хуулиар иргэдэд мэдээлэл сайн өгч байх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байх
52. улсын эмнэлэгүүд малчдад хүрч үйлчлэх боломж хомс, маш их артай бас мөнгө шаардаж үздэг болсон цаг
53. урьдчилан сэргийлэх мэдлэгтэй болгох сургалт хийх
54. Урьдчилсан сэргийлэх үзлэгт хамрагдах
55. үзлэг оношилгоо хиймээр байна
56. Үзлэг оношилгоо хийх
57. хаваржаа зунжаа, өөрийн мэдлийн худаг, усан сантай болох, өөрийн гэсэн бэлчээртэй болох
58. Хамтын тэтгэвэрийн хууль нийгмийн даатгалын шимтгэлийг хамтран амьдрагч үр хүүхдэд нь өвлөж авч байх хууль шаардлагатай
59. хөдөөгийн малчдаа амбулторын үзлэг шинжилгээнд хамруулах, махны үйлдэртэй болвол малчид мах түүхий эдээ нийлүүлэх
60. хөрсний усны асуудал дээр төр захиргаа бодлогоо чиглүүлэх хэрэгтэй байна. сүүлийн жилүүдэд усны түвшин маш багасаж байна
61. Худаг ус олноор гаргах, ус өргүүрийг гүн өрмийн худгуудад суурилуулах
62. Худаг усны асуудал муу усны ундрага бага шавхаж мал услахад худаг дээрээ өнжин хонодог болсон шинээр ус гаргах
63. хүн малын ундны усыг шинээр гаргах, сум бүр шүдний эмчтэй болох
64. цаг газар муу хэцүү байна. ийм үед малчидаа жоохон дэмжиж ажиллавал сайн байна
65. эмнэлэгийн салбарууд нь эрүүл мэндийн даатгалд хамрагдсан иргэдийн судалгааг сайн харж үйлчилгээг шуурхай хүргэх
66. эмнэлэгийн үйлчилгээг сайжруулах эмч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх зам харилцааг сайжруулах өргөсөн төн

67. эмнэлэгийн үйлчилгээг хөдөөнөөс ирсэн хүнд ойчир дараалалгүй үзүүлж баймаар байна.
68. энэ талын хуулийг ойр ойрхон өөрчилж байгаа нь муу үр дагавартай, хууль журмын дагуу жил бүр төлж байгаа нь хохирч байна
69. эрүүл мэндийн байгууллагууд нь даатгалдаа хамрагдсан иргэдэд хангалттай үйлчилж байх хэрэгтэй
70. эрүүл мэндийн байгууллагын түргэн шуурхай үйлчилгээ чухал байна.
71. эрүүл мэндийн даатгал залуучуудад зарим өрхийн орлогогүй иргэдэд хүнд байна.
72. эрүүл мэндийн даатгал төлөөд ашиглахгүй байна. эргүүлэн тодорхоой худийг буцаан олгож байх
73. эрүүл мэндийн даатгал төлөөд эмнэлэгч үзүүлж амжихгүй байгаа тул ашиггүй төлөлт хийдэг
74. эрүүл мэндийн даатгалаа төлөөд явахдаа эмнэлэгийн байгууллагаар үйлчлүүлэхэд өөдөөс мөнгө нэхдэг, над шиг тэр болгон эмнэлэгээр явдаггүй хүмүүст буцаагаад зохих
75. Эрүүл мэндийн даатгалд хамруулж өгөх
76. Эрүүл мэндийн даатгалын ач тусыг нэмэгдүүлэх, хамтын тэтгэвэрийн хууль малчдын хөдөлмөрийг үнэлэх, малчдын хариуцлагыг нэмэгдүүлэх
77. эрүүл мэндийн даатгалын сангаас олгогддог эмчилгээ үйлчилгээний тоог нэмэгдүүлэх
78. эрүүл мэндийн даатгалын үнэ багасгах, өндөр насны тэтгэвэр адил тэгш байх
79. эрүүл мэндийн нарийвчилсан үзлэгт 3-5 жилд 1 удаа хамруулж байх
80. эрүүл мэндийн нарийн мэргэжлийн үзлэг хийх
81. эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт малчдыг хамруулах, малын ариутгал тарилга нэгдсэн байдлаар хөнгөлөлттэй хамруулах
82. Эрүүл мэндийн үзлэг улирал тутамд хөдөөгүүр явж байх
83. эрүүл мэндийн үзлэгт хамруулах
84. Эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
85. эрүүл мэндийн хувьд байнгын үзлэг мөн хөнгөлөлттэй эмийн жор олгож өгч байх

### **Мал аж ахуй эрхлэгчдийн эдийн засаг, нийгмийн байдлыг сайжруулах талаар зөвлөмж**

Мал аж ахуй эрхлэгч өрхийн орлогын зөрүү түүний шалтгаан, ахуй амьдрал, аж ахуйдаа зарцуулдаг цагийн хуваарь, Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгал төлдөг эсэх, МАА-тай холбоотойгоор гарсан эрүүл мэндийн байдал, өвчлөл, түүнээс урьдчилан сэргийлэх мадлэгтэй эсэх, мөн эрүүл мэнд болон нийгмийн байдлын хувьд авч хэрэгжүүлвэл зохих арга хэмжээний талаар санал бодлоо

хуваалцах асуумж судалгаанд Өмнөговь аймгийн 15 сумын 58 багийн нийт 215 малчин сонгогдлоо.

Аймаг, сумын түвшинд:

Малчдын өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх:

- Орлого багатай өрхүүдийг малжуулах ажлыг өргөжүүлэх талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Малын ашиг шимийг сайжруулж, эрчимжүүлсэн мал аж ахуйг нэмэгдүүлэх
- Малчдад эрүүл мэндээ хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, энэ асуудлаар малчид, сум, багийн удирдлагад сургалт зохион байгуулж байх
- Малчдыг унд ахуйн цэвэр усаар хангах ажлыг сайжруулж, ундны усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх,
- Жил бүр тодорхой хуваарийн дагуу эрүүл мэндтэй холбогдолтой өдрүүд (гар угаах, нойлын, чихрийн шижингийн, дэлхийн усны өдөр г.м)-ийг угтаж 7 хоног, сарын аян зохион байгуулж тэмдэглэдэг журам тогтоон хэвшүүлэх, эдгээр асуудлаар малчдад зохих мэдлэг олгох ажил зохиож байх
- Эрүүл аж төрөх сэдвээр хэвлэл, мэдээллээр сурталчилах ажлыг тогтмол зохиож, санамж, зөвлөмж, гарын авлагаар хангах
- Малчдыг жилд нэгээс доошгүй удаа нарийн мэргэжлийн эмч нарийн бүрэлдэхүүн, лабораторийн шинжилгээ (зүрхний бичлэг, дотор эрхтний эхо, цусны ерөнхий болон биохими, шээсний шинжилгээ г.м)-тэйгээр эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт оруулан, шаардлагатай малчдыг эмнэлгийн тогтмол авах, энэ зорилгоор явуулын амбулатори ажлуулах
- Малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар зохион байгуулалттай арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Малын махны экспорт болон арьс ширний үйлдвэрийг бий болгох талаар шийдвэр гаргагчдад уламжлах, ажил зохион байгуулах

Малчдад:


- Эмнэлгийн байгууллагын хуваарийн дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол орж, эмчийн зөвлөгөөг биелүүлэх
- Өвчлөх бүрд эмнэлэгт хандаж эмчийн зөвлөгөөгөөр эм хэрэглэн эмчлүүлж байх
- Зуслан, намаржаа болон хаваржаанд нүхэн жорлон ашиглаж нүүхдээ булж байх
- Эрүүл мэндийн байгууллагаас болон орон нутгийн удирдлагын шийдвэрээр гарсан сургалтанд хамрагдаж байх



Малын тооны өсөлт бойжсон төлөөс хамааралтай эсэхийг EVEIWS программ дээр шинжилгээг хийсэн болно.

Он	Малын тоо	Бойжсон төл
2008	1684939	486656
2009	1755215	490461
2010	1010327	56468
2011	1223459	406786
2012	1419253	393591
2013	1653264	469222
2014	1849043	450151
2015	2055765	530744
2016	2313963	540484
2017	2654388	664257

Графикаар харуулвал:



Sample: 2008 2017

Included observations: 10

Covariance

Correlation	MALTOO	TUL
MALTOO	2.19E+11 1.000000	
TUL	5.98E+10 <b>0.855129</b>	2.24E+10 1.000000

Дээрх программын үр дүнгээс уншигдсан хүснэгтийг тайлбарлавал.

Хамаарлын хүчийг  $r$  үсгээр тэмдэглэдэг ба  $0 < r < 1$  хооронд утга авна.

$r$  нь 0-рүү тэмүүлж байвал хамааралгүй

$r$  нь 1-рүү тэмүүлж байвал хамааралтай

**$r=0.855129$**  утга нь малын тоо, төл бойжилт 2 нь хүчтэй хамааралтай гэж гарч байна.

Малын тооны өсөлт нь бойжсон төлөөс хамаарч байна гэсэн дүгнэлтэнд хүрч байна.